

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн  
төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Chuluuntsetsegd@audit.gov.mn">Chuluuntsetsegd@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЗД	Засаг дарга
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН АЧИТ АМИРЛУУЛАГЧ  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА О.МӨНХЗУЛ ТАНАА

2024-02-03 № САА-2024/190-АА-СН-НУБ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон **5,292.8** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасантай болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 6 дугаар хавсралттай тус тус нийцээгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Иргэдэд үзүүлэхээр зөвшөөрөгдсөн 4 төрлийн тусламж үйлчилгээнээс, гэрийн тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ зэрэг 2 төрлийн үйлчилгээг үзүүлж байснаас тайлант онд шинээр сэргээн засах үйлчилгээг нэмж үзүүлэн 31,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

ӨЭМТ нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжиж “*Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл*” гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр хүн амд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлан нь төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, тайлагнагдах зохицуулалтгүй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ нь ӨЭМТ-тэй байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-г ЭМДҮЗ-ийн 07 дугаар тогтоолд заасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэж “Хангалттай” буюу 80.5 хувьтай үнэлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 сарын 22-ны өдрийн А/104 дугаар тушаалаар батлагдсан “Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай” журмын дагуу аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын дарга нь ӨЭМТ-ийн даргатай гэрээ байгуулж, санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавиагүй байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,072,803.67	31,459,649.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,297,419.67	13,633,701.92
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,297,419.67	13,633,701.92
3121	Төгрөг	11,297,419.67	13,633,701.92
31211	Төрийн сангийн харилцах	11,297,419.67	13,633,701.92
33	АВЛАГА		17,371,950.00
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		17,371,950.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8,775,384.00	453,997.92
351	Түүхий эд материал	8,775,384.00	453,997.92
3513	Эм боох материал	8,775,384.00	453,997.92
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,079,196.76	73,030,940.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,079,196.76	73,030,940.73
392	Биет хөрөнгө	56,079,196.76	73,030,940.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,300,000.00	8,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,639,999.84	-8,299,999.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,050,270.85	88,384,870.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,366,592.71	-28,699,110.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,761,900.00	33,530,625.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,026,381.54	-20,185,445.54
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	76,152,000.43	104,490,590.57
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	76,152,000.43	104,490,590.57
51	Засгийн газрын хувь оролцоо	76,152,000.43	104,490,590.57
	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,833,664.00	12,833,664.00
511	Өмч: - төрийн	12,833,664.00	12,833,664.00
512	Хуримтлагдсан үр дүн	63,318,336.43	91,656,926.57
5121	Өмнөх үеийн үр дүн	63,318,336.43	63,318,336.43
5122	Тайлант үеийн үр дүн		28,338,590.14
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	76,152,000.43	104,490,590.57

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	391,721,893.16	397,669,981.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,070,887.16	16,239,491.35
120	Нийтлэг татварын бус орлого	26,070,887.16	16,239,491.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,070,887.16	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,070,887.16	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		8,858,425.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		7,381,065.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	365,651,006.00	381,430,490.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	127,878,580.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,878,580.00	
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237,772,426.00	381,430,490.20
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	351,881.00	

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237,420,545.00	381,430,490.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,852,307.13	369,331,391.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,852,307.13	369,331,391.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,502,307.13	359,713,391.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,668,635.99	229,375,805.16
210101	Үндсэн цалин	189,483,013.99	229,375,805.16
210102	Нэмэгдэл	33,185,622.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,210,266.72	27,958,647.79
210201	Тэтгэврийн даатгал	25,210,266.72	27,958,647.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,302,016.00	2,920,239.00
210302	Түлш, халаалт	2,299,616.00	2,919,639.00
210303	Цэвэр, бохир ус	2,400.00	600
2104	Хангамж, бараа материалын зардал	16,811,428.95	21,729,549.00
210401	Бичиг хэрэг	2,417,600.00	2,019,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,482,479.00	3,674,309.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	889,267.08	1,492,940.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	191,600.00	183,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,830,482.87	14,359,550.00
2105	Нормативт зардал	52,443,904.87	46,018,178.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,568,904.87	44,328,178.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,000.00	1,690,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,628,350.00	3,136,800.00
210604	Урсгал засвар	6,628,350.00	3,136,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,501,685.00	7,910,850.00
210702	Дотоод албан томилолт	4,501,685.00	7,910,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,658,014.00	995,464.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,495,000.00	190,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,064.00	37,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		637,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	54,450.00	59,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,278,005.60	19,667,858.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,262,120.00	2,516,277.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,015,885.60	17,151,581.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,350,000.00	9,618,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,350,000.00	9,618,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		4,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,350,000.00	4,918,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,869,586.03	28,338,590.14
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,869,586.03	28,338,590.14

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	369,151,006.00	364,058,540.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,500,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,500,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	365,651,006.00	364,058,540.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	127,878,580.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	127,878,580.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237,772,426.00	364,058,540.20
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	351,881.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237,420,545.00	364,058,540.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	357,866,933.79	361,722,257.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,866,933.79	361,722,257.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,516,933.79	352,104,257.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,668,635.99	229,375,805.16
210101	Үндсэн цалин	189,483,013.99	229,375,805.16
210102	Нэмэгдэл	33,185,622.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,210,266.72	27,958,647.79
210201	Тэтгэврийн даатгал	25,210,266.72	27,958,647.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,302,016.00	2,920,239.00
210302	Түлш, халаалт	2,299,616.00	2,919,639.00
210303	Цэвэр, бохир ус	2,400.00	600
2104	Хангамж, бараа материалын зардал	16,148,481.08	21,729,549.00
210401	Бичиг хэрэг	2,306,700.00	2,019,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,482,479.00	3,674,309.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	889,267.08	1,492,940.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	191,600.00	183,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,278,435.00	14,359,550.00
2105	Нормативт зардал	41,216,065.00	30,315,726.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,341,065.00	28,625,726.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	875,000.00	1,690,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,549,650.00	28,381,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,790,400.00	22,395,900.00
210602	Тавилга	6,130,900.00	2,849,000.00
210604	Урсгал засвар	6,628,350.00	3,136,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,501,685.00	7,910,850.00
210702	Дотоод албан томилолт	4,501,685.00	7,910,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,468,014.00	995,464.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,305,000.00	190,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,500.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,064.00	37,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		637,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	54,450.00	59,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,452,120.00	2,516,277.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,452,120.00	2,516,277.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,350,000.00	9,618,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,350,000.00	9,618,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		4,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,350,000.00	4,918,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,284,072.21	2,336,282.25
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11,284,072.21	2,336,282.25
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,297,419.67
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,633,701.92

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,833,664.00	63,318,336.43	76,152,000.43
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
8	Тайлант үеийн үр дүн		28,338,590.14	28,338,590.14
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,833,664.00	91,656,926.57	104,490,590.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	344,667,000.0	361,722,257.9	17,055,257.9	104.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,667,000.0	361,722,257.9	17,055,257.9	104.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,667,000.0	352,104,257.9	7,437,257.9	102.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,360,000.0	229,375,805.1	4,015,805.1	101.78
2101	Үндсэн цалин	225,360,000.0	229,375,805.1	4,015,805.16	101.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,200,000.00	27,958,647.79	2,758,647.79	110.95
2102	Тэтгэврийн даатгал	25,200,000.00	27,958,647.79	2,758,647.79	110.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,224,000.00	2,920,239.00	1,303,761.00	69.13
2103	Түлш, халаалт	3,360,000.00	2,919,639.00	-440,361.00	86.89
2103	Цэвэр, бохир ус	300,000.00	600	-299,400.00	0.20

2104	Хангамж, бараа материалын зардал	17,454,000.00	21,729,549.00	4,275,549.00	124.50
2104	Бичиг хэрэг	1,992,000.00	2,019,150.00	27,150.00	101.36
2104	Тээвэр, шатахуун	4,200,000.00	3,674,309.00	-525,691.00	87.48
2104	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,080,000.00	1,492,940.00	412,940.00	138.24
2104	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	183,600.00	3,600.00	102.00
2104	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,002,000.00	14,359,550.00	4,357,550.00	143.57
2105	Нормативт зардал	58,200,000.00	30,315,726.00	27,884,274.0	52.09
2105	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000,000.00	28,625,726.00	1,374,274.00	95.42
2105	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,700,000.00	1,690,000.00	-10,000.00	99.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	28,381,700.00	18,381,700.0	283.82
2106	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	22,395,900.00	2,395,900.00	111.98
2106	Тавилга	2,000,000.00	2,849,000.00	849,000.00	142.45
2106	Урсгал засвар	2,000,000.00	3,136,800.00	1,136,800.00	156.84
2107	Томилолт, зочны зардал	4,800,000.00	7,910,850.00	3,110,850.00	164.81
2107	Дотоод албан томилолт	4,800,000.00	7,910,850.00	3,110,850.00	164.81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	995,464.00	195,464.00	124.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	190,000.00	190,000.00	
2108	Даатгалын үйлчилгээ	50,000.00	49,500.00	-500.00	99.00
2108	Тээврийн хэрэгслийн татвар	40,000.00	37,064.00	-2,936.00	92.66
	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00	-3,000.00	88.00
2108	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		637,000.00	637,000.00	
2108	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		59,900.00	59,900.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,629,000.00	2,516,277.00	887,277.00	154.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,629,000.00	2,516,277.00	887,277.00	154.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,000,000.00	9,618,000.00	618,000.00	106.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	9,618,000.00	618,000.00	106.87
2132	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4,500,000.00	4,700,000.00	200,000.00	104.44
2132	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	4,918,000.00	418,000.00	109.29
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	344,667,096.0	364,058,540.2	19,391,444.2	105.63
134	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	344,667,096.0	364,058,540.2	19,391,444.2	105.63
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	344,667,096.0	364,058,540.2	19,391,444.2	105.63
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		11,297,419.67	11,297,419.6	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,633,701.92	13,633,701.9	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төв /цаашид ӨЭМТ гэх/ нь “Ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд чанар хүртээмжтэй хүргэж эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар тэдний эрүүл мэндийн байдалд ахиц гаргах, улмаар өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэн бэхжүүлэх, өрхийн эрүүл мэндийн төвд техник технологийн дэвшлийг нэвтрүүлж, стандартын шаардлагад нийцсэн ээлтэй тусламж үйлчилгээг үзүүлэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт үйлчлэх,
- Нотолгоонд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох,
- Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай, аюулгүй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх
- Тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлох, эмчлэх, сувилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, хөнгөвчлөх гэх мэт хүрээний дагуу үзүүлнэ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- 2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 6 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан,
- 2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 7 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төв нь ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу нэг иргэний нормативаар тооцож олгох санхүүжилт, тусламж

үйлчилгээний санхүүжилт зэрэг гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Гэвч төсвөөс олгож буй гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн зарцуулалт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас хэрэгжилтийг дүгнэж, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 161,674.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 45,490.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,297.4	13,633.7	2,336.3
Авлага		17,371.9	17,371.9
Бараа материал	8,775.3	453.9	-8,321.4
Үндсэн хөрөнгө	96,112.1	130,215.4	34,103.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>116,184.8</b>	<b>161,674.9</b>	<b>45,490.1</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	116,184.8	161,67.9	45,490.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө</b>	<b>116,184.8</b>	<b>161,674.9</b>	<b>45,490.1</b>

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 13,633.7 мянган төгрөг болж 2,336.3 мянган төгрөгөөр өссөн нь тусламж үйлчилгээний төрөл нэмэгдэж, гүйцэтгэлийн санхүүжилт өссөнөөс шалтгаалсан байна.
- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 17,371.9 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 453.9 мянган төгрөг болж 8,321.3 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс бараа материал, эм эмнэлгийн хэрэгслийг зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 130,215.4 мянган төгрөг болж 34,103.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас 8,858.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, өөрийн хөрөнгөөр 25,244.9 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж /УВЧ, Шээсний анализатор, нярайн шаралтын аппарат, зүрхний цахилгаан бичлэг/ худалдан авсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2023 оны төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1 хөтөлбөр 1 арга хэмжээгээр тооцон ЭМДС-аас нэг иргэний нормативт санхүүжилтээр 357,866.9 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас тус эрүүл мэндийн төвийн ЭМДС-аас төвлөрөх санхүүжилтийг **344,667.1** мянган төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Гүйцэтгэлээр ЭМДС-ийн нэг иргэнээр тооцож олгох санхүүжилтээр 333,058.5 мянган төгрөг, эмчилгээ үйлчилгээний санхүүжилтээр 31,000.0 мянган төгрөг зэрэг 2 арга хэмжээний нийт **364,058.5** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний урсгал үйл ажиллагаанд **361,722.2** мянган төгрөгийг зарцуулж, 104.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **361,722.2** мянган төгрөг буюу 104.9 хувьтай тайлагнагдсан нь тайлант онд төлөвлөгдөөгүй шинэ тусламж үйлчилгээний 1 хөтөлбөр нэмэгдэж 31,000.0 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж, цалин, НДШ-ийн зардалд 28,738.3 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ноогдох нормотивт	344,667.0	332,987.0	-11,683.0	96.6
2	Тусламж үйлчилгээний зардал		28,738.3	28,738.3	
	<b>Дүн</b>	<b>344,667.0</b>	<b>361,722.3</b>	<b>17,055.3</b>	<b>104.9</b>

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Шууд худалдан авах босго үнээс давсан 30,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Азын нахиа, Эм импекс, Архон, Монгол фарм зэрэг байгууллагуудтай шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ачит амирлуулагч өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 352,852.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу **5,292.8** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.3.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

Шууд худалдан авах босго үнээс давсан нийт 30,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа -20.0 сая төгрөг,” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2

дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үе шатны ажлыг хэсэгчлэн хийх буюу түүвэрт хамруулан аудитыг гүйцэтгэсэн байна.

Аудитаар ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **40,230.2** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 11,604.5 мянган төгрөгийн 3 зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 28,625.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

#### **5.1 Төлбөрийн акт**

1. Сарын цалингаас гадна тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийн орлогоос эмч, ажилтнуудад нийт **11,604.5** мянган төгрөгийн цалин нэмж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалт болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### **5.2 Албан шаардлага**

1. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмч, ажилтнуудын цалинг шинэчлэн батлагдсан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг үндэслэн шинэчлэн тогтоож, олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг шинэчлэн баталсан цалингийн сүлжээг үндэслэн тогтоох албан шаардлага хүргүүлэв.

2. 2023 оны жилийн эцэст эм, эмнэлгийн хэрэгслийн тооллого хийж, тооцоо бодоогүйгээс бодит үлдэгдлийг санхүүгийн тайланд / *үлдэгдэлгүйгээр тайлагнасан /* тусгаж, тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь *"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"*, 12.2.1: *"Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"*, 20 дугаар зүйлийн 20.2 дахь *"Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:"* 20.2.6 дахь *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,*

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст бараа материалын тооллого хийж, үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтгүйгээр, зөвхөн эмийн зардлыг цуглуулах хүснэгтийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн **28,625.7** мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Заглуулсан		Заглуулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн										

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	11,604.5	1	11,604.5								
Бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүйгээс бодит үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй	1				1							
Цалинг шинэчлэн тогтоогоогүй	1				1							
Анхан шатны баримтын бүрдүүлэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	28,625.7	1	11,604.5	1	28,625.7						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>40,230.2</b>	<b>1</b>	<b>11,604.5</b>	<b>3</b>	<b>28,625.7</b>						

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	30,000.0					1	30,000.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>30,000.0</b>					<b>1</b>	<b>30,000.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>30,000.0</b>					<b>1</b>	<b>30,000.0</b>

/мянган төгрөгөөр/